

МАСТЕРФАЙЛ ИРҮҮЛЭХ ЗААВАРЧИЛГАА

Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан. Үүнтэй холбоотойгоор хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн дансдад өөрчлөлт орсон тул холбогдох дансдын бүртгэлийг дараах холбоосоор орж танилцана уу. <https://shorturl.at/Epet9>

Тайлан мэдээг шивж ирүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд:

STATISTICS – Статистик мэдээлэл

- Гишүүн иргэнийг хүйсээр ангилан мэдээлэх;
- Гишүүн хуулийн этгээдийг гүйцэтгэх захирлын мэдээллийг хүйсээр ангилах;
- Гишүүний оруулах хувь хөрөнгийн доод хэмжээг ХЗХ-ны дүрмээр тогтоосон хувь хөрөнгийн дүнгээр мэдээлэх;
- Гишүүдийн насжилт, боловсролын түвшнээр ангилахад гишүүн иргэдийн тоотой тэнцүү байх;
- Гишүүн хуулийн этгээдгүй тохиолдолд зээлдэгч, хадгаламж эзэмшигчдийн мэдээлэлд хуулийн этгээд хэсэгт аливаа утга бичихгүй байх;
- Хадгаламж болон зээлийн ЖДХ-г сараар шивэх бөгөөд хүүг аравт, зуутын орноор нөхөхгүй байх; Жишээ нь: гурав аравны хоёр хувийн хүүтэй бол зөв 3.2% | буруу 0.32%, 0.032%
- Зээлдэгчдийн мэдээллийг чанараар ангилахад нийт зээлдэгчдийн тоотой тэнцүү байх;
- Хадгаламж эзэмшигч болон зээлдэгчийн мэдээллийг насжилт, боловсролоор ангилахад хадгаламж эзэмшигч болон зээлдэгч иргэдийн тоотой тэнцүү байх;
- 1 зээлдэгчид ногдох зээлийн дундаж дүнг шивэх;
- Сонголттой утгыг заавал гараас сонгоно.

GB-Гүйлгээ үлдэгдлийн тайлан тэнцэл

- Нүдэнд (cell) аливаа бодолт хийж болохгүй зөвхөн гараас анхны утгыг шивэх;
- Copy, Paste хийхдээ "values" буюу томъёогүй форматаар хуулах;
- Санаатай болон санамсаргүй байдлаар нүдийг cut хийсэн эсхүл томъёотой утга paste хийснээс үүдэн алдаа заасан тохиолдолд мастерфайлыг шинээр татан авч дахин эхнээс нь шивэх шаардлага үүсэхийг анхаарах;
- Өмнөх үеийн хуримтлагдсан орлого, алдагдал нүднээс бусад нүдэнд сөрөг утгатай дүн гараас шивэхгүй байх;
- Нүдэнд шивэх тоон утгын нарийвчлал нь зуу (0.99)-ны нарийвчлалаас хэтрэхгүй. Жишээ: зөв 150,375.23 | буруу 150,375.234 Зууны нарийвчлал хэтэрснээс үүдэн тайлан зөрүүтэй гэсэн алдаа зааж, DCS системд тайлан хүлээн авахгүй байхыг анхаарна уу!

LOAN-PD – Зээл олголт, эргэн төлөлт, зээлийн зориулалт, хүүгийн судалгаа

- Зээлийн мэдээллийг иргэн, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэж 4 төрлөөр ангилан мэдээлэхээс гадна хүйсээр ангилах;
- Зээлийн хугацааны ангилал болон чанарын ангиллын мэдээллийг заавал шивэх бөгөөд эцсийн үлдэгдэл дүн балансын утгатай уягдсан тул зөрүүтэй тохиолдолд DCS системд тайлан хүлээн авахгүй алдаа заах тул анхаарах;

- Зээлийн хугацааны ангиллын мөр(6+7+8+9+10+11+12)-ийн нийлбэр зээлийн чанарын ангиллын мөр(13+14+15+16+17)-ийн нийлбэр болон НИЙТ ДҮН мөр(1)-тэй тэнцүү байна;
- Зээлийн хугацаагаар ангилсан дүнг шивснээр ALM тайлангийн зээлийн ангиллын дүн татагдахыг анхаарах;
- Зээлийн хугацааны ангиллыг шивэхдээ зээлийн гэрээний хугацаа 6 сар бол 3-6 сар хугацаатай ангилалд бүртгэнэ;
- ЖДХүү сараар талбарт ЖДХ-г сараар шивэх бөгөөд хүүг аравт, зуутын орноор нөхөхгүй. Жишээ нь: гурав аравны хоёр хувийн хүүтэй бол зөв 3.2% | буруу 0.32%, 0.032%
- Зээлийн дүнг зориулалт бүрийн харгалзах нийлбэр дүнгээр тооцож тайлагнах бөгөөд гишүүн иргэн, хуулийн этгээдээр, хуулийн этгээдийг мөн дотор нь 3 ангилж авч байгааг анхаарах;
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалтай холбоотой мэдээллийг дараах холбоосоор авна уу! [ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ \(legalinfo.mn\)](http://legalinfo.mn)
- Зээлийн эхний үлдэгдлийн нийт дүн өмнөх оны жилийн эцсийн дүнтэй тэнцүү байх;
- Шинээр олгосон зээл талбарт тайлант хугацаанд шинээр олгосон зээлийн мэдээллийг шивэх ба зээлийн чанарын ангилал болон хугацааны ангилалд орсон өөрчлөлтийг өөрчлөлт орсон харгалзах ангилалд бүртгэн төлөлт хийгдсэн зээл хэсэгт мөн дүнгээр харгалзах ангилалд бүртгэх;
- Тухайн зээлийн зориулалт бүрд олгосон зээлийн дундаж хугацаагаар бүртгэх;
- Төлөлт хийгдсэн зээл хэсэгт тайлант хугацаанд төлөлт хийгдсэн зээлийн дүн болон тоог шивж хаагдсан зээл хэсэгт зээлээ төлж дууссан хаагдсан зээлийн дүн, тоог бичих;
- Зээлдэгчийн зээлийн үлдэгдэлд нэмж зээл олгосон тохиолдолд "Шинээр олгосон зээл" хэсэгт зээлийн дүнг шивж, зээлдэгчийн дансны тоог шивэхгүй;
- "Зээлийн эцсийн үлдэгдэл дүн" болон "дансны тоо" алдаа зааж улайрч байгаа тохиолдолд хасах утгатай болсон буюу алдаатай шивэгдсэн байх тул засварлан шивэх;
- "Дансны тоо" хэсэгт зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн дансны тоогоор тайлагнах тул нийт дансны тоо статистик мэдээллийн зээлдэгчдийн тоотой тэнцүү байх шаардлагагүйг анхаарах;
- "ХХХХ"-ээр тэмдэглэсэн хэсгийг шивэхгүй;
- ЗОЭТЗЗХС тайланд хуулийн этгээдийг ангилахдаа Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд заасны дагуу дараах байдлаар ангилан бүртгэнэ. Үүнд;
 - 5.1.1."бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;
 - 5.1.2."жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;
 - 5.1.3."дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 1.0--2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг."
- LOAN-green Ногоон зээлийн судалгааны тайлан
- Зөвхөн ногоон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг гишүүддээ олгож буй ХЗХ-д нөхөх бөгөөд ногоон зээлийн ангилалтай холбоотой мэдээллийг дараах холбоосоор авна уу. <https://www.toc.mn/publication/mongol-ulsyn-nogoon-taksonomi>

- Бусад хэсэг LOAN-PD тайлангийн тайлбартай адил байна.

SAVING-Хадгаламжийн хүүгийн судалгаа

- Хадгаламжийн хугацааны ангиллын эцсийн үлдэгдэл дүн балансын дүнтэй уягдсан тул зөрүүтэй тохиолдолд DCS системд тайлан хүлээн авахгүй алдаа заах тул анхаарах;
- "Хадгаламжийн хугацааны ангилал" хэсгийг нөхөхдөө хадгаламжийн гэрээнд заагдсан хугацаагаар ангилан бүртгэнэ. Хугацаагаар ангилсан хадгаламжийн эцсийн үлдэгдэл дүн "Гүйлгээ үлдэгдлийн тайлан тэнцэл" дэх хугацаатай хадгаламжийн ангиллын дүнтэй тэнцүү байхыг анхаарах;

40 BIG LOAN – 40 том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгийн тайлан

- Хүйсийн мэдээлэл нэмэгдсэн бөгөөд сонгох утга тул зөвхөн гараас утга татна.
- Иргэнийг хүйсээр ангилахаас гадна хуулийн этгээдийн мэдээллийг мөн гүйцэтгэх захирлын хүйсээр ангилан тайлагнах;
- 1 зээлдэгчийн ялгаатай зээлийн мэдээллүүд шивэгдсэн байх магадлалтай тул зээлдэгчийн тоог 40-д ойртуулах зорилгоор 50 хүртэл нэмсэн бөгөөд нэг зээлдэгчийн нийт зээлийн мэдээллийг нэгтгэн харах багана нэмсэн тул та регистрийн дугаарыг үнэн зөв шивэх;
- Зээлдэгчдийн мэдээллийг бүрэн, үнэн зөв шивж илгээхэд анхаарах.

INSIDER - Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгийн тайлан

- Нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг 2 оронтой тоо бүхий ижил кодоор бүртгэн тайлагнана. Гишүүдийг нэгдмэл сонирхолтой этгээдүүд болохыг таних үүднээс ижил кодоор бүртгэж байгаа тул мэдээллийг бүрэн, үнэн зөв шивж илгээх;
- Иргэнийг хүйсээр ангилахаас гадна хуулийн этгээдийн мэдээллийг мөн гүйцэтгэх захирлын хүйсээр ангилан тайлагнана.

40 BIG SAVING, BIG SHARES судалгаануудыг шивэхдээ иргэнийг хүйсээр ангилахаас гадна хуулийн этгээдийн мэдээллийг мөн гүйцэтгэх захирлын хүйсээр ангилан тайлагнахыг анхаарна уу.